

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Гэр бүлийн төлөө залбирал

Таны зүрх сэтгэлийн хамгийн үнэт эрдэнэс юу вэ? Бид юуг үнэн бөгөөд эрхэм хэмээн үзнэ, тэр нь бидний зүрхний эрдэнэс болдог. Харин тэр эрдэнэс маань шүтээн ч болж мэднэ. Бидний Сайн Бурхан ариун бөгөөд цэвэр учраас биднээс Өөр шигээ ариун байхыг хүсдэг.

Бурхан Аав биднийг шаналал, зовлонгийн галаар дагуулан хөтөлдөг. Ингэснээр зүрхний маань бохирдол шатаж, цэвэрлэгддэг. “Зүрх сэтгэлээ ариусга, хоёрдмол сэтгэлтүүд ээ” (Иаков 4:8). Бурхан Аав биднийг зовлон шаналал дундуур дагуулахдаа, зүрхэнд маань байгаа хир буртаг, шүтээнүүдийг арилгах зорилготой байдаг. Бурханаас ирсэн сорилтууд амаргүй байдаг ч тэвчсэний дараа зөвт байдал болон амар тайвны үр жимсийг авчирдаг.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

Танд найдах итгэлийг өгөөч. (Исаиа 46:4)

4. Эзэн минь, Ботсван болон Өмнөд Африкт гэр бүл салалтыг эрэлхийлж буй хосуудыг эвлэрүүлж өгөөч. Эхнэр, нөхөр хоёул Танд захирагдах болтугай. (Колосай 3:13)

5. Бурхан Аав минь, Бразилын эцэг эхчүүд өдөр тутмынхаа амьдралд хүүхдүүддээ Есүстэй авралын харилцаатай болохыг зааж сургахад сайн үлгэр жишээ болгож өгөөч. (Ефес 6:4)

6. Эзэн минь, Камбож дахь орхигдсон салсан ээжүүдийг тэнхрүүлж, нөхрүүдээсээ дэмжлэггүй хүүхдүүдээ ганцаараа өсгөж буй тэднийг хангаж өгөөч. (Дуулал 54:4)

7. Бурхан минь, хүйсийн тэнцвэргүй байдал, хөдөө нутгийн ядуурал, хууль сахиулах сул байдал зэргээс үүдэлтэйгээр Хятадад үргэлжилж буй хүчээр гэрлүүлэх, бэр худалдаалах асуудлуудыг Та таслан зогсоож өгөөч. (Дэд хууль 24:7)

8. Бурхан минь, Хорватын ахмад настнууд, ялангуяа ганцаардсан хүмүүсийг халамжилж, гэр бүл, нийгмийнх нь хайр, хүндэтгэлийг мэдрүүлж өгөөч. (Гэтэлгэгч 20:12)

9. Эзэн минь, Эсватинийн үр хүүхэдгүй Христэд итгэгч эмэгтэйчүүд гэр бүл, нийгмээсээ зовлон шаналал, доромжлол амсдаг. Таны нигүүлслээр тэдэнд хүүхэд төрүүлэх ивээлийг хайрлаач. (1 Самуел 1:20)

10. Эзэн минь, Финландад залуучуудаар үйлдэгдэж буй хүчирхийллийн гинжийг таслаач. Эцэг эх, багш нарт эдгээр өсвөр үеийнхэнд ухаалгаар хандах мэргэн ухаан хайрлаач. (Дуулал 102:1)

11. Бурхан Аав минь, эцэг эхчүүдэд хүүхдүүдийнхээ хэрэгцээг ойлгох мэргэн ухаан өгч, хайр энэрэл, хүндтлээр үлгэрлэгч байлгаж өгөөч. (Колосай 3:21)

12. Бурхан минь, онцгой хэрэгцээтэй хүүхдүүдэд гэр бүл, дэмжих тогтолцооны зүгээс шаардлагатай тусламжийг авах боломжийг нээгээч. (Исаиа 41:10)

13. Бурхан минь, Христэд итгэгч эцэг эхчүүд Таны талаарх үнэн, эрүүл дүр төрхийг хүүхдүүддээ ойлгуулж, тэд Таныг таньж, Танаас холдохгүй байхад нь мэргэн ухаан хайрлаач. (Сургаалт үгс 22:6)

1. Эзэн минь, Афганистанд тэжээлийн дутагдалд орсон эмэгтэйчүүд, хүүхдүүдийн хэрэгцээг хангаж өгөөч. Христэд итгэгчдэд ажлын байр олдохгүй, хүнс ховор байгаа энэ үед тэднийг Та халамжлаач. (Иов 38:41)

2. Бид Албанид гэр бүл салалтын золиос болсон хүүхдүүдийн төлөө залбирч байна. Эзэн минь, тэднийг Өөртөө ойртуулж, зовлон шаналал, амиа хорлох бодлыг нь өөрчилж, сайн, итгэлтэй найзуудтай болгож өгөөч. (Матай 19:13)

3. Бурхан минь, Бельгийн ахмад хүмүүс Тантай харилцаагүй амьдарч байна. Тэднийг Өөрийнхөө оршихуй руу ойртуулж,



14. Аав аа, Энэтхэгийн гэр бүл, нийгэмд эв зохицол, харилцан хүндэтгэл, дэмжлэгтэй уур амьсгалыг бий болгооч. (Ром 15:5)

15. Бурхан Аав минь, Индонез дахь 24 сая ядуу өрхийн хэрэгцээнд туслахад Христийн байгууллага, сүмүүдийг сэргээж идэвхжүүлээч. (1 Иохан 3:17)

16. Японы эмэгтэйчүүд хүүхдүүдээ өсгөх, ахмад настнуудыг асрах хоёрын дунд дарамттай байна. Тэд Христэд ачаагаа даатгаж, амралт олж авах болтугай. (Дуулал 20:2)

17. Эзэн минь, Кабилийн багийн гишүүдэд хүчирхийлэл, ганцаардал, хавчлага, сэтгэл гутралд өртсөн эмэгтэйчүүд, гэр бүлүүдтэй үр дүнтэй харилцах мэргэн ухаан, чадвар хайрлаач. (Галат 6:2)

18. Бурхан Аав аа, Мьянмарт охидын боловсрол, эдийн засгийн боломжийг хязгаарлаж, эрт жирэмслэх эрсдэлийг нэмэгдүүлж буй хүүхдийн гэрлэлтийн заншлыг өөрчлөх соёлын өөрчлөлт авчирч өгөөч. (Матай 18:10)

19. Бурхан минь, Монголд үргүйдэлтэй тэмцэж буй эмэгтэйчүүдийг тэнхрүүлж, үр хүүхдийг өгөх болтугай. (Дуулал 113:9)

20. Эзэн минь, Непалын бэлэвсэн эмэгтэйчүүдийг дахин гэрлэхийг соёл болоод нийгэм нь хориглодог. Тэднийг тэнхрүүлж, хэрэгцээг нь хангаж өгөөч. (Дуулал 68:6)

21. Аав аа, Нидерланд дахь ганц бие эмэгтэйчүүдийг зоригжуулж, тэдэнд найз нөхөд, хамаатан садан нь гэр орноо нээж, тусламжийн гараа өгөх болтугай. (Ром 12:13)

22. Эзэн минь, Нигерийн Христэд итгэгч хосууд гэр бүлээ Таны үг дээр тулгуурлан босгож, Сатан гэр бүлийг нь нураах боломж олгохгүй байх болтугай. (Ефес 5:21-30)

23. Аав аа, Умард Македонд өнчин, орхигдсон хүүхдүүд болон эмзэг бүлгийн залуучууд орон нутгийн Христэд итгэгчид, сүм чуулганаас хайр, хамгаалал, дэмжлэг авах болтугай. (Дуулал 146:9)

24. Эзэн минь, Папуа Шинэ Гвинейн ганц бие ээжүүд хүүхдүүдээ өсгөхөд шаардлагатай санхүүгийн боломж, шударга цалинтай ажилтай болох болтугай. (Дэд хууль 24:14-15)

25. Эзэн минь, Румыны гэрлээгүй итгэгчид буруу харилцаанд татагдалгүй, сэтгэл хөдлөлийн хэрэгцээгээ Танаар хангадаг болох болтугай. (Дуулал 37:4)

26. Бурхан минь, Сербийн гэр бүлүүд Христ дээр суурилж, хайр, итгэл, хүндлэлээр дүүрэн байж, хүүхдүүдийнхээ хувьд аюулгүй орчинг бий болгож өгөөч. (Ефес 5:31)

27. Аав аа, Өмнөд Африкт өлсгөлөнд нэрвэгдсэн хүүхдүүдэд өдөр тутмын талхыг нь өгөөч. Байгууллагууд тэдэнд шим тэжээлтэй хүнс, шаардлагатай халамжийг хүргэхэд үр дүнтэй ажиллах болтугай. (Матай 6:11)

28. Бурхан минь, Танзанид гэр бүл салалтаас болж орхигдож буй эмэгтэйчүүд, хүүхдүүдэд эвлэрэл, эдгэрэл авчирч өгөөч. (2 Коринт 13:11)

29. Тимор-Лестед бэлэвсэн эмэгтэйчүүдийг ачаа мэт үзэж, орхигдуулахгүй байлгахад туслаач. Харин тэднийг гэр бүл, нийгэм нь тэвэрч, халамжилж болтугай. (Иаков 1:27)

30. Аав аа, Вьетнамын нөхөрүүд эхнэрүүдээ үнэлж, дэмжиж, гэр бүлийн болон хүүхэд хүмүүжлийн үүрэг хариуцлагыг хамтдаа үүрэх соёлыг тогтогтоох болтугай. (Фил. 2:1-2)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Бурхан минь, Таны нэрийг тунхаглагч Христэд итгэгч гэр бүлүүд гэрэл болон жишээ болж, олон хүнд итгэлийн замыг заах болтугай. (Матай 5:16)
2. Ааваа, Монголын эрэгтэйчүүдийг Христ шиг хайрлаж, хамгаалагч, тэжээгч, үлгэр дууриал үзүүлэгч болгооч. (Ефес 5:25)
3. Эзэн минь, Монголын сүмүүд, Христийн байгууллагуд ядуу, орхигдсон гэр бүлүүдэд Таны хайрыг үйлдлээр дамжуулан харуулах болтугай. (Лук 7:22)

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.